

## “ОНЦГОЙ БАЙДЛЫН БАЙГУУЛЛАГЫН ХАРЬЯА НЭГЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ДОТООД ХЯНАЛТ, ШАЛГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ АРГАЧЛАЛ, ЗААВАР”-ЫН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын үйл ажиллагаанд хууль, тогтоомж, дүрэм, журам стандарт, салбарын бодлого, үйл ажиллагааны зорилт, хөтөлбөр, төлөвлөгөө, төсөв, төслийн хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт шинжилгээ үнэлгээ, аудит хийх, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, удирдлагыг бодит мэдээллээр хангах, бие бүрэлдэхүүний сахилга хариуцлага дэг журмыг бэхжүүлэх, илэрсэн зөрчлийг арилгах, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх, аюулгүй байдлыг хангуулах харилцааг зохицуулж, нотолгоо баримт бүхий үр дүнд суурилсан үйл ажиллагааг сайжруулах зорилгоор Онцгой байдлын ерөнхий газрын даргын зөвлөлөөс өгсөн чиглэлийн хүрээнд Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2022 оны А/88 дугаар тушаалаар батлагдсан “Онцгой байдлын байгууллагын харьяа нэгжийн үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалт зохион байгуулах аргачлал, заавар”-ын төслийг шинэчлэн боловсруулав.

Журмын төслийн 2.2-т Онцгой байдлын ерөнхий газрын бүтцийн нэгж, харьяа салбар, нэгжид төлөвлөгөөлт, төлөвлөгөөт бус иж бүрэн шалгатад хамрагдах тайлант хугацааг, 2.3-т биелэлтийн шалгалт зохион байгуулах чиглэл, 2.4-т төлөвлөгөөт бус иж бүрэн шалгалт болон албаны шалгалт зохион байгуулах үндэслэл, шийдвэрийг тодорхой тусгасан.

Одоо хэрэгжиж буй журамд ижил санааг илэрхийлсэн шалгуур үзүүлэлтийг нэгтгэж, зарим шаардлагагүй шалгуур үзүүлэлтийг журмын төсөлд хасч, шалгах чиглэлд шаардлагатай шалгуур үзүүлэлтийн заалтыг нэмж тусгасан. Үүнд :

Удирдлага зохион байгуулалт, төлөвлөлт, дотоод үйл ажиллагааны чиглэлээс 3 шалгуур үзүүлэлтийг, Гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны чиглэлээс 3 шалгуур үзүүлэлтийг, Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны чиглэлээс 5 шалгуур үзүүлэлтийг, Эрүүл мэнд, үйлдвэрлэл, хангалт үйлчилгээний үйл ажиллагааны 5 шалгуур үзүүлэлтийг, Гамшгаас хамгаалах судалгаа, эрдэм шинжилгээний үйл ажиллагааны чиглэлээс 5 шалгуур үзүүлэлтийг тус тус хасч, Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны чиглэлд 12 шалгуур үзүүлэлтийг нэмж тусгасан.

Зааврыг шинэчилснээр Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2022 оны “Аргачлал заавар батлах тухай” А/88 дугаар тушаалыг хүчингүй болсон тооцож, шинэ журмыг батлагдсан өдрөөс мөрдөж эхэлнэ.

Иймд Онцгой байдлын ерөнхий газрын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан “Онцгой байдлын байгууллагын харьяа нэгжийн үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалт зохион байгуулах аргачлал, заавар”-ыг шинэчлэн гаргаж батлуулахаар ажиллаж байгаа тул Онцгой байдлын ерөнхий газрын даргын зөвлөлийн гишүүн та холбогдох саналыг тусган ирүүлнэ үү.

**ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗАР**

ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны... дугаар  
сарын ... -ний өдөр

Дугаар А/ .....

Улаанбаатар хот

Аргачлал заавар батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4, Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”, 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Монгол Улсын Шадар сайдын 2018 оны 107 дугаар тушаалаар батлагдсан “Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын харьяа нэгжийн үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалт зохион байгуулах журам”-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Онцгой байдлын ерөнхий газрын харьяа салбар нэгжийн үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалт зохион байгуулах аргачлал”-ыг нэгдүгээр, “Нэгжийн үйл ажиллагаанд хяналт шалгалт зохион байгуулах чиглэл, шалгуур үзүүлэлтийн жагсаалт”-ыг хоёрдугаар, “Хяналт, шалгалт зохион байгуулах заавар”-ыг гуравдугаар, “Албан тушаалтныг шалгах шалгуур үзүүлэлт”-ийг дөрөвдүгээр хавсралтын ёсоор тус тус баталсугай.

2. Шинэчлэгдсэн аргачлал, зааврыг мөрдөж ажиллахыг Хяналт шалгалтын газар (хурандаа Б.Батболд), төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын дарга, захирагч нарт тус тус үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тэргүүн дэд дарга, хурандаа Ж.Чүлтэмсүрэнд даалгасугай.

4. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2022 оны А/88 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА,  
ХОШУУЧ ГЕНЕРАЛ

Г.АРИУНБУЯН

## Төсөл

Онцгой байдлын ерөнхий газрын даргын  
2024 оны ... дугаар сарын ...-ний өдрийн  
А/...дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

### ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЪЯА САЛБАР, НЭГЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ДОТООД ХЯНАЛТ, ШАЛГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ АРГАЧЛАЛ

#### Нэг. Зорилго.

1.1. Төрийн бодлого, шийдвэр, хууль тогтоомж, байгууллагын хэтийн болон тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, дэвшүүлсэн зорилтыг хангах чиглэлээр Онцгой байдлын ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийн болон харьяа салбар, нэгжийн авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, ажил үйлчилгээ, үйл ажиллагаа, алба хаагчдын ажил, гүйцэтгэлийн үр дүнг үнэлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үр нөлөө, бүтээмжийг дээшлүүлэх, үр дүнг үнэлэхэд энэхүү аргачлалын зорилго оршино.

#### Хоёр. Хамрах хүрээ, бодлого

- 2.1. Онцгой байдлын ерөнхий газрын харьяа салбар, нэгжийн үйл ажиллагаанд :
  - 2.1.1 Удирдлага зохион байгуулалт, төлөвлөлт, дотоод үйл ажиллагаа
  - 2.1.2 Гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах үйл ажиллагаа
  - 2.1.3 Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа
  - 2.1.4 Санхүүгийн үйл ажиллагаа
  - 2.1.5 Улсын нөөцийн анги, салбарын үйл ажиллагаа
  - 2.1.6 Эрүүл мэнд, үйлдвэрлэл, хангалт үйлчилгээний үйл ажиллагаа
  - 2.1.7 Гамшгаас хамгаалах судалгаа, эрдэм шинжилгээний үйл ажиллагааны чиглэлээр хяналт шалгалт явуулна.
  - 2.1.8 Алба хаагчдын албан тушаалын тодорхойлолтод заагдсан болон мэргэжил ур чадварын түвшин тогтоох үзлэг шалгалтаар авсан ажил арга хэмжээний нийлбэр үнэлгээг хамааруулна.
- 2.2. Онцгой байдлын ерөнхий газрын бүтцийн нэгж, харьяа салбар, нэгжид төлөвлөгөөлт, төлөвлөгөөт бус иж бүрэн шалгалт зохион байгуулахад тухайн жилийн болон өмнөх 2 жилийн үйл ажиллагаанд шалгалт зохион байгуулж үндсэн чиг үүргийн хүрээнд чиглэл тус бүрээр нэг бүрчлэн үнэлнэ.
- 2.3. Онцгой байдлын ерөнхий газрын бүтцийн нэгж, харьяа салбар, нэгжид иж бүрэн шалгалтын хүрээнд хүргүүлсэн зөвлөмжийн дагуу биелэлтийн шалгалтыг зохион байгуулна.
- 2.4. Төлөвлөгөөт бус болон албаны шалгалтыг тухайн нэгж, алба хаагч, иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн гомдол, мэдээлэл, хүсэлтийг харгалзан удирдлагын шийдвэрээр зохион байгуулна.
- 2.5. Хяналт шалгалтын давтамж хуваарь, эрсдэлийг харгалзан тухайн жилд зохион байгуулах хяналт шалгалтыг төлөвлөн Онцгой байдлын ерөнхий газрын даргаар батлуулж, хэрэгжүүлнэ.

Гурав. Үр дүнг үнэлэх аргачлал

3.1. Аргачлал зааварт тусгагдсан ажил, арга хэмжээг Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан үнэлгээний арга зүйг баримтлан нотломжид үндэслэн шалгуур үзүүлэлтийн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг дараахь аргачлалын дагуу хувиар илэрхийлэн үнэлнэ;

$$\text{Хэрэгжилт} = \frac{\text{Хүрсэн түвшин} - \text{Суурь түвшин}}{\text{Зорилтот түвшин} - \text{Суурь түвшин}} \cdot 100\%$$

3.3. Тухайн ажлын зорилт, арга хэмжээний хүрсэн түвшинг тоо болон чанараар илэрхийлэх боломжгүй үед хэрэгжилтийн хувийг тодорхойлоход дараах аргачлалаар тооцно: Үүнд:

3.3.1. “үр дүнтэй”–зорилт, арга хэмжээ нь оновчтой тодорхойлогдсон, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн, удирдлага зохион байгуулалт сайн, үр дүн гарсан бол 100 хувь;

3.3.2. Зорилт, арга хэмжээний хүрэх түвшинд бүрэн хүрээгүй боловч зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан, холбогдох байгууллагын шийдвэр гарсан, гол үр дүн нь гарч эхэлж байгаа бол 90.0 хувь;

3.3.3. Тавьсан зорилт, арга хэмжээнд хүрэх зорилгоор өөрсдөөс хамаарах шийдвэрийг гаргасан, санхүүгийн асуудал шийдвэрлэгдсэн, дээд шатны байгууллагад өргөн барьсан буюу гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр гарч эхэлж байгаа бол 70.0 хувь;

3.3.4. Тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл болон боловсруулалтын шатны ажил бүрэн хийгдсэн, ажил тодорхой хэмжээнд эхэлсэн бол 50.0 хувь;

3.3.5. Тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл ажил хийгдэж дуусаад боловсруулалтын шатанд байгаа бол 30 хувь;

3.3.6. Тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай тооцоо, судалгаа хийх, асуудал тодорхойлох зэрэг бэлтгэл хангахтай холбогдсон үйл ажиллагааг авч эхэлж байгаа эсвэл хэрэгжүүлэх талаар ямар нэгэн ажил зохион байгуулаагүй бол биелэлтийг “0” хувь.

3.4. Онцгой байдлын ерөнхий газрын харьяа салбар, нэгжийн үйл ажиллагаанд хяналт шалгалт зохион байгуулах чиглэл, шалгуур үзүүлэлтийн жагсаалт:

№	Үйл ажиллагааны үр дүнгийн чиглэл	Үнэлэх үзүүлэлт /тоогоор/	Оноо	Өгсөн оноо	Хувь чанар
3.4.1	Удирдлага зохион байгуулалт, төлөвлөлт, дотоод үйл ажиллагаа	23	0-100		
3.4.2	Гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах үйл ажиллагаа	11	0-100		
3.4.3	Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа	61	0-100		
3.4.4	Санхүүгийн үйл ажиллагаа	20	0-100		
3.4.5	Улсын нөөц, хүмүүнлэгийн тусламжийн үйл ажиллагаа	9	0-100		
3.4.6	Эрүүл мэнд, үйлдвэрлэл, хангалт үйлчилгээний үйл ажиллагаа	41	0-100		
3.4.7	Гамшгаас хамгаалах судалгаа, эрдэм шинжилгээний үйл ажиллагаа	11	0-100		
3.4.8	Албан тушаалтныг шалгах шалгуур үзүүлэлт	Албан тушаалтны тоогоор	0-100		

<b>Нийт оноо</b>	<b>181 + (3.4.8)</b>	<b>0-100</b>		
------------------	--------------------------	--------------	--	--

3.5. Аргачлалын 3.3-т тусгагдсан чиглэл тус бүрийн үнэлгээг дараах аргачлалаар тооцно: Тухайлбал, хэрэгжүүлбэл зохих 19 ажил, үр дүнтэй 15 ажил, гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр гарсан 2 ажил, зорилт арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл ажил хийгдсэн 1 ажил, үр дүнгүй 1 ажил үнэлэгдсэн тохиолдолд:

$$\begin{array}{l}
 15 \times 100 = 1500 \\
 2 \times 70 = 140 \\
 1 \times 30 = 30 \\
 1 \times 0 = 0
 \end{array}
 \qquad
 \frac{15 \times 100 + 2 \times 70 + 1 \times 30 + 1 \times 0}{19} = 86.47 \text{ оноо}$$

3.6. Аргачлалын 3.2, 3.3 дахь аргачлалын дагуу чиглэл тус бүрт авсан онооны нийлбэрийн дундаж оноо нь тухайн салбар нэгжийн ерөнхий үнэлгээ болно.

90-100 оноо “А” буюу “Маш сайн”

80-89.9 оноо “В” буюу “Сайн”

70-79.9 оноо “С” буюу “Хангалттай”

60-69.9 оноо “D” буюу “Дутагдалтай”

0-59.9 оноо “F” буюу “Хангалтгүй”

3.7. Үнэлэх зааврын шалгуур үзүүлэлт нь тухайн ажил арга хэмжээг хэрэгжүүлэх чиглэлээр гаргасан удирдлагын баримт бичигт заагдсан заалт, хугацаа, хүрэх түвшинг харгалзана.

3.8. Тухайн нэгжийн үйл ажиллагааг үнэлэхдээ тушаалын хоёрдугаар хавсралтад заасан үйл ажиллагаа үр дүнгийн чиглэл, шалгуур үзүүлэлтийн заалтын дагуу өгсөн үнэлгээнд, тушаалын дөрөвдүгээр хавсралтын дагуу албан тушаалтнуудыг үнэлсэн дундаж үнэлгээг хамтатган тооцно.

3.9. Албан тушаалтныг шалгах шалгуур үзүүлэлтийн онолын мэдлэгийн шалгалтын тестийг жил бүр, бие бялдрын бэлтгэлжилтийн нормативыг шинэчлэгдсэн тухай бүр Онцгой байдлын ерөнхий газрын чиглэл хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж шинэчлэн гаргаж Хяналт шалгалт хариуцсан бүтцийн нэгжид ирүүлнэ.

3.10. Ажлын хэсгээс шалгагдсан нэгжийн үйл ажиллагаа, ололт амжилт, зөрчил дутагдлыг харгалзан ерөнхий үнэлгээг өгөхдөө 3 хүртэлх оноог нэмж, хасаж тооцож болох бөгөөд илтгэх хуудсанд шалтгаан нөхцөлийг дурдаж, нотломжийг хавсаргасан байна.

3.11. Шалгалт зохион байгуулах чиглэлээр Онцгой байдлын ерөнхий газрын бүтцийн нэгжүүд арга зүй, мэдээ, мэдээллээр хангаж, хамтран ажиллана.

**Төсөл**

Онцгой байдлын ерөнхий газрын даргын  
2024 оны ... дугаар сарын ...-ний өдрийн  
А/...дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

**ОНЦГОЙ БАЙДЛЫН БАЙГУУЛЛАГЫН ГАЗАР, ХЭЛТЭС, НЭГЖИЙН ҮЙЛ  
АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ ШАЛГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЧИГЛЭЛ, ШАЛГУУР  
ҮЗҮҮЛЭЛТИЙН ЖАГСААЛТ**

№	Нэгж байгууллага	Үйл ажиллагааны үр дүнгийн чиглэл	Шалгуур үзүүлэлт	Заалтын тоо	
				Чиглэл	Нийт
1	Орон нутгийн Онцгой байдлын газар	Удирдлага зохион байгуулалт, төлөвлөлт, дотоод үйл ажиллагаа	Бүх заалт, шалгуур үзүүлэлт	23	115
		Гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах үйл ажиллагаа	Бүх заалт, шалгуур үзүүлэлт	11	
		Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа	3.1.1-3.8.12	53	
		Санхүүгийн үйл ажиллагаа	4.1.1-4.2.7, 4.3.1-4.3.8	19	
		Улсын нөөц, хүмүүнлэгийн тусламжийн үйл ажиллагаа	Бүх заалт, шалгуур үзүүлэлт	9	
2	Орон нутгийн Онцгой байдлын хэлтэс	Удирдлага зохион байгуулалт, төлөвлөлт, дотоод үйл ажиллагаа	1.1.2–1.1.4, 1.1.6, 1.2.1-1.2.3, 1.3.2-1.3.4, 1.4.1-1.4.3, 1.4.6, 1.4.7	15	61
		Гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах үйл ажиллагаа	2.1.1-2.1.6	6	
		Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа	3.1.1-3.1.3, 3.1.5-3.3.3, 3.4.2, 3.4.3, 3.5.1, 3.5.2, 3.6.1, 3.8.1-3.8.12,	35	
		Санхүүгийн үйл ажиллагаа	4.3.3, 4.3.5-4.3.8	5	
3	Нийслэлийн Онцгой байдлын газар	Удирдлага зохион байгуулалт, төлөвлөлт, дотоод үйл ажиллагаа	Бүх заалт, шалгуур үзүүлэлт	23	93
		Гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах үйл ажиллагаа	Бүх заалт, шалгуур үзүүлэлт	11	
		Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа	3.1.1-3.5.1, 3.5.3-3.7.13	39	

		Санхүүгийн үйл ажиллагаа	4.1.1-4.2.7, 4.3.1-4.3.8	19	
4	Дүүргийн Онцгой байдлын хэлтэс	Удирдлага зохион байгуулалт, төлөвлөлт, дотоод үйл ажиллагаа	1.1.1-1.2.4, 1.3.2-1.3.4, 1.4.1-1.4.7	21	84
		Гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах үйл ажиллагаа	Бүх заалт, шалгуур үзүүлэлт	11	
		Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа	3.1.1-3.2.8, 3.4.2-3.5.2, 3.6.1, 3.7.1, 3.8.1-3.8.12,	33	
		Санхүүгийн үйл ажиллагаа	4.1.1-4.2.7, 4.3.1-4.3.8	19	
5	Онцгой байдлын ерөнхий газрын дэргэдэх Гамшиг судлалын үндэсний хүрээлэн	Удирдлага зохион байгуулалт, төлөвлөлт, дотоод үйл ажиллагаа	1.1.1, 1.1.2, 1.1.4, 1.1.5, 1.1.7, 1.2.2, 1.2.3, 1.3.2, 1.3.3, 1.4.1, 1.4.2, 1.4.6	12	43
		Гамшгаас хамгаалах судалгаа, эрдэм шинжилгээний үйл ажиллагаа	Бүх заалт, шалгуур үзүүлэлт	11	
		Санхүүгийн үйл ажиллагаа	Бүх заалт, шалгуур үзүүлэлт	20	
6	Үндэсний аврах бригад	Удирдлага зохион байгуулалт, төлөвлөлт, дотоод үйл ажиллагаа	1.1.1, 1.1.2, 1.1.4, 1.1.5, 1.1.7-1.4.7	21	72
		Гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах үйл ажиллагаа	2.1.3, 2.1.4, 2.1.7	3	
		Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа	3.1.6, 3.3.1-3.4.2, 3.5.1, 3.5.2, 3.6.1, 3.7.1-3.7.8, 3.8.1-3.8.6, 3.8.9-3.8.12	28	
		Санхүүгийн үйл ажиллагаа	4.1.1-4.2.7, 4.3.1-4.3.8	19	
7	Уул уурхайн аврах 09 дүгээр анги	Удирдлага зохион байгуулалт, төлөвлөлт, дотоод үйл ажиллагаа	1.1.1, 1.1.2, 1.1.4, 1.1.5, 1.1.7, 1.2.2, 1.2.3, 1.3.1-1.4.7	19	70
		Гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах үйл ажиллагаа	2.1.3, 2.1.4, 2.1.7	3	



		Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа	3.1.6, 3.3.1-3.4.2, 3.5.1, 3.5.2, 3.6.1, 3.7.1-3.7.8, 3.8.1-3.8.6, 3.8.9-3.8.12	28	
		Санхүүгийн үйл ажиллагаа	4.1.1-4.2.7, 4.3.1-4.3.8	19	
8	Ар тал хангалтын 115 дугаар анги,	Удирдлага зохион байгуулалт, төлөвлөлт, дотоод үйл ажиллагаа	1.1.2, 1.1.4, 1.1.5, 1.1.7-1.4.7	20	67
		Гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах үйл ажиллагаа	2.1.3, 2.1.7	2	
		Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа	3.1.6, 3.3.3, 3.4.2, 3.5.1, 3.7.1-3.7.8	12	
		Эрүүл мэнд, үйлдвэрлэл, хангалт үйлчилгээний үйл ажиллагаа	6.5.1-6.6.6	14	
		Санхүүгийн үйл ажиллагаа	4.1.1-4.2.7, 4.3.1-4.3.8	19	
9	Давтан сургалт, сургалт сэргээн заслын 113 дугаар анги,	Удирдлага зохион байгуулалт, төлөвлөлт, дотоод үйл ажиллагаа	1.1.2, 1.1.4, 1.1.5, 1.1.7-1.4.7	20	57
		Гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах үйл ажиллагаа	2.1.3, 2.1.7	2	
		Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа	3.3.3, 3.4.2, 3.5.1, 3.7.2, 3.7.5, 3.7.6	6	
		Эрүүл мэнд, үйлдвэрлэл, хангалт үйлчилгээний үйл ажиллагаа	6.1.1-6.2.3	9	
		Санхүүгийн үйл ажиллагаа	Бүх заалт, шалгуур үзүүлэлт	20	
10	Онцгой байдлын ерөнхий газрын дэргэдэх 185, 112, 179 дүгээр анги,	Удирдлага зохион байгуулалт, төлөвлөлт, дотоод үйл ажиллагаа	1.1.2, 1.1.4, 1.1.5, 1.1.7-1.4.7	20	51
		Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа	3.3.3, 3.4.2, 3.5.1	3	
		Санхүүгийн үйл ажиллагаа	4.1.1-4.2.7, 4.3.1-4.3.8	19	
		Улсын нөөц, хүмүүнлэгийн тусламжийн үйл ажиллагаа	Бүх заалт, шалгуур үзүүлэлт	9	

11	Аврагч биеийн тамир, техник спортын хороо дугаар анги 120	Удирдлага зохион байгуулалт, төлөвлөлт, дотоод үйл ажиллагаа	1.1.2, 1.1.4, 1.1.5, 1.1.7-1.4.7	20	62
		Гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах үйл ажиллагаа	2.1.3, 2.1.7	2	
		Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа	3.3.3, 3.4.2, 3.5.1, 3.7.1-3.7.6	9	
		Эрүүл мэнд, үйлдвэрлэл, хангалт үйлчилгээний үйл ажиллагаа	6.7.1-6.9.3	11	
		Санхүүгийн үйл ажиллагаа	Бүх заалт, шалгуур үзүүлэлт	20	
12	Онцгой байдлын ерөнхий газрын дэргэдэх дүгээр анги, 121	Удирдлага зохион байгуулалт, төлөвлөлт, дотоод үйл ажиллагаа	1.1.2, 1.1.4, 1.1.5, 1.1.7-1.4.7	20	55
		Гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах үйл ажиллагаа	2.1.3, 2.1.7	2	
		Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа	3.3.3, 3.4.2, 3.5.1	3	
		Эрүүл мэнд, үйлдвэрлэл, хангалт үйлчилгээний үйл ажиллагаа	6.3.1-6.4.7	10	
		Санхүүгийн үйл ажиллагаа	Бүх заалт, шалгуур үзүүлэлт	20	
13	Шуурхай удирдлага, зарлан мэдээллийн төв дүгээр анги 119	Удирдлага зохион байгуулалт, төлөвлөлт, дотоод үйл ажиллагаа	1.1.2, 1.1.5, 1.2.2, 1.2.3, 1.3.1-1.3.5, 1.4.6, 1.4.7	11	39
		Гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах үйл ажиллагаа	2.1.3, 2.1.7	2	
		Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа	3.3.1-3.5.1, 3.6.1, 3.6.2	7	
		Санхүүгийн үйл ажиллагаа	4.1.1-4.2.7, 4.3.1-4.3.8	19	
14	Агаараас эрэн хайх аврах дүгээр анги 111	Удирдлага зохион байгуулалт, төлөвлөлт, дотоод үйл ажиллагаа	1.1.2, 1.1.4, 1.1.5, 1.1.7-1.4.7	20	68
		Гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг	2.1.3, 2.1.7	2	

		бууруулах үйл ажиллагаа			
		Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа	3.1.4, 3.3.3, 3.4.2, 3.5.1, 3.6.1, 3.6.3, 3.7.1-3.7.8, 3.9.1-3.11.2	26	
		Санхүүгийн үйл ажиллагаа	Бүх заалт, шалгуур үзүүлэлт	20	
15	Гал түймэр унтраах, аврах анги, Эрэн хайх, аврах анги, салбар	Удирдлага зохион байгуулалт, төлөвлөлт, дотоод үйл ажиллагаа	1.1.2, 1.2.2, 1.4.1	3	19
		Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа	3.4.3- 3.5.2, 3.6.1, 3.8.1-3.8.12	16	
16	Эрэн хайх, аврах бүлэг	Удирдлага зохион байгуулалт, төлөвлөлт, дотоод үйл ажиллагаа	1.1.2, 1.2.2, 1.4.1	3	18
		Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа	3.5.1, 3.5.2, 3.6.1, 3.8.1-3.8.12	15	

---oOo---

**Төсөл**

Онцгой байдлын ерөнхий газрын даргын  
2024 оны ... дугаар сарын ...-ний өдрийн  
А/...дугаар тушаалын гуравдугаар хавсралт

**ХЯНАЛТ, ШАЛГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЗААВАР**

**Нэг. Удирдлага зохион байгуулалт, төлөвлөлт, дотоод үйл ажиллагаа:**

№	Шалгуур үзүүлэлт	Авсан оноо	Хувь чанар	Дундаж оноо хувь	
1.1	Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үр дүн	1.1.1. Төрийн бодлого, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, төсөл хөтөлбөр, тушаал шийдвэрийн хэрэгжилт /Хугацаат тайлан мэдээний боловсруулалт, чанар, үр дүнг тооцсон байдал/ 1.1.2. Онцгой байдлын ерөнхий газрын даргатай тухайн жилд байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, үр дүнг тооцсон байдал 1.1.3. Аймаг, нийслэлийн Засаг даргатай тухайн жилд байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, үр дүнг тооцсон байдал 1.1.4. ОБЕГ-ын тухайн онд дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх төлөвлөгөө, түүний биелэлт, үр дүнг тооцсон байдал 1.1.5. Нэгжийн хэмжээнд боловсруулсан эрх зүйн баримт, бичгийн стандарт 1.1.6. Орон нутгийн Онцгой комиссын үйл ажиллагаа, шийдвэрийн биелэлт, үр дүнг тооцсон байдал 1.1.7. Нэгдсэн менежментийн тогтолцооны хэрэгжилт, үр дүн /ISO9001:2015, ISO45001:2018/			
1.2	Үйл ажиллагааны төлөвлөлт	1.2.1. Нэгжийн болон салбар нэгжийн тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөлт, тайлан, чанар, үр дүнг тооцсон байдал 1.2.2. Алба хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөлт, баталгаажуулалт, үнэлгээний баг байгуулан үнэлж дүгнэсэн байдал 1.2.3. Дотоод үйл ажиллагааны төлөвлөлт, хяналт шинжилгээ үнэлгээ, үр дүнг тооцсон байдал /Удирдлагаас өгсөн үүрэг чиглэл, шуурхай хуралдааны үүрэг гэх мэт/ 1.2.4. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэл, тайлан, хэрэгжилт			

1.3	Хүний нөөцийн бүртгэл судалгаа, цэргийн албаны зохион байгуулалт	1.3.1. Хүний нөөцийн цахим бүртгэлийн сан, архив, албан хэрэг хөтлөлт, хадгалалт, хамгаалалт			
		1.3.2. Алба хаагчдын цэргийн хэргийн мэдлэг, цэрэгжилт, жагсаалч байдал, зохион байгуулалт			
		1.3.3. Нэгжийн сахилга, ёс зүйн албаны үйл ажиллагааг зохион байгуулсан байдал			
		1.3.4. Бие бүрэлдэхүүний сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний боловсруулалт, албаны болон мэргэжлийн сургалт, үр дүнг тооцсон байдал			
		1.3.5. Хүний нөөцийн бүртгэл судалгаа /шагнал урамшуулал, сайшаал, шийтгэл, тэтгэвэр, тэтгэмж, нийгмийн судалгаа, бүртгэл хөтлөлт г.м/			
1.4	Дотоод үйл ажиллагаа, албаны зохион байгуулалт	1.4.1. Байгууллагын дотоод албаны зохион байгуулалт, албаны өрөө, тасалгааны тохижилт, соёлжилт байдал, эмх цэгц, ажлын байрны аюулгүй байдал			
		1.4.2. Алба хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах чиглэлээр хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээ			
		1.4.3. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн ажиллах журам, төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнг тооцсон байдал			
		1.4.4. Ахмадын зөвлөлийн үйл ажиллагаа, холбогдох хууль дүрмийн хэрэгжилт			
		1.4.5. Байгууллагын эзэмшил газар, барилга байгууламжийн гэрчилгээ, ашиглалт, захирамжийн бүрэн бүтэн байдал,			
		1.4.6. Тамга, тэмдэг түших, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх зааврын хэрэгжилт, хариуцах албан тушаалтныг тушаалаар томилсон байдал			
		1.4.7. Бие бүрэлдэхүүнийг яаралтай цуглар дохио өгч бэлтгэл бэлэн байдал шалгасан байдал /хувь хүний бэлтгэл, бэлэн байдал/			
<b>23</b>			<b>0-100</b>		

**Хоёр. Гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах үйл ажиллагаа**

№	Шалгуур үзүүлэлт		Авсан ОНОО	Хувь чанар	Дундаж ОНОО хувь
2.1	Сургалт, сурталчилгаа олон нийттэй харилцах	2.1.1. Гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд сайн дурынхны үйл ажиллагаа, оролцоог хангаж чадавхжуулсан байдал			
		2.1.2. Гамшиг, гал түймэр, аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээг цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан зохион байгуулсан байдал			
		2.1.3. Гамшгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах үйл ажиллагааг олон нийтэд сурталчилсан бүртгэл судалгаа			
		2.1.4. Тухайн орон нутагт тохиолдсон аюулт үзэгдэл, ослын талаарх судалгаа шинжилгээний үр дүнг үндэслэн арга хэмжээ зохион байгуулсан байдал, дүрс бичлэг, гэрэл зургийн архив, үүсгэсэн байдал			
		2.1.5. Гамшгаас хамгаалах ангиллын сургалт зохион байгуулсан байдал, цахим бүртгэл, үр дүн, тоон мэдээ, бодит байдал			
		2.1.6. Гамшгаас хамгаалах чиглэлээр сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж батлуулж, хэрэгжилт, тайлан мэдээ, үр дүнг тооцсон байдал			
		2.1.7. Байгууллагын вэб сайтыг шинэчлэх, мэдээллийн баяжилт хийсэн байдал			
2.2	Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаа	2.2.1. Гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ хийх эрх бүхий хуулийн этгээдийн бүртгэл, мэдээлэл, хянагдсан тайлан, хүргүүлсэн зөвлөмж, биелэлт			
		2.2.2. Гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах чиглэлээр зарцуулах хөрөнгийг орон нутгийн төсвөөс шийдвэрлүүлсэн байдал, харьцуулсан судалгаа			
		2.2.3. Гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ зохион байгуулсан байдал			
		2.2.4. Гамшгаас хамгаалах орон нутгийн зөвлөлүүдийн үйл ажиллагаа, шийдвэр, төлөвлөлт, хэрэгжилт үр дүн тооцсон байдал			
<b>11</b>			<b>0-100</b>		

**Гурав. Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа:**

№	Шалгуур үзүүлэлт	Авсан ОНОО	Хувь чанар	Дундаж ОНОО ХУВЬ	
3.1	Гамшгаас хамгаалах төлөвлөлт	3.1.1. Орон нутгийн гамшгаас хамгаалах ерөнхий төлөвлөлт, баталгаажуулалт, тодотгол, хэрэгжилт			
		3.1.2. Алба, мэргэжлийн ангийн гамшгаас хамгаалах төлөвлөлт, баталгаажуулалт, тодотгол, хэрэгжилт, бодит байдал			
		3.1.3. Аж ахуйн нэгж, байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөлт, баталгаажуулалт, тодотгол, бүртгэл судалгаа			
		3.1.4. Харилцан ажиллагааны төлөвлөгөө, хэрэгжилт, үр дүн /хил залгаа Онцгой байдлын газар, тусгалсан чиг үүргийн байгууллагууд/			
		3.1.5. Бүх шатны алба, мэргэжлийн ангид бэлэн байдлын үзлэг зохион байгуулсан бүртгэл судалгаа, үр дүн			
		3.1.6. Нүүлгэн шилжүүлэлт хийх төлөвлөлт, дайчилгаагаар ажиллах хүч хэрэгслийн томилгоожилт бэлтгэл бэлэн байдал			
		3.1.7. Аймаг, нийслэл, сум, дүүргийн хэмжээнд гамшгаас хамгаалах иж бүрэн болон команд штабын сургууль дадлага зохион байгуулсан байдал, үр дүн			
3.2	Гал түймрийн болон Гамшгаас хамгаалах улсын хяналт	3.2.1. Улсын хяналтын байцаагчийн дундаж үзүүлэлтийг хангасан байдал			
		3.2.2. Улсын хяналтын чиглэлээр гаргасан эрх зүйн баримт бичгийн боловсруулалт, бүртгэл			
		3.2.3. Цахим бүртгэлд өдөр тутмын ажлын мэдээ оруулсан байдал			
		3.2.4. Улсын хяналтын байцаагчийн авсан зөрчил шалган шийдвэрлэсэн байдал, бүртгэл судалгаа			
		3.2.5. Зөрчлийн хэрэг үүсгэн шалган шийдвэрлэж, прокпорт хянуулсан байдал, бүртгэл			
		3.2.6. Өргөдөл, гомдол, хэрэг зөрчлийн шийдвэрлэлт, акт тэмдэглэл хөтлөлт			
		3.2.7. Улсын онц чухал болон онц аюултай объектуудын бүртгэл, судалгаа, хяналт шалгалт хийгдсэн байдал			

		3.2.8. Заавал биелүүлэх албан шаардлага, мэдэгдлийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ			
		3.2.9. Барилга байгууламжийн зураг төсөлд хяналт хийсэн болон байнгын ашиглалтад оруулах комисст ажиллаж үүрэг даалгаврын биелэлтийг хангуулсан материалыг иргэн хуулийн этгээдээс баталгаажуулан гаргуулж авсан байдал /тэмдэгтийн хураамжийн төлбөр/			
3.3	Холбоо мэдээллийн техник хэрэгслийн бэлэн байдал, төлөвлөлт, мэдээллийн аюулгүй байдал	3.3.1. Шуурхай удирдлага зарлан мэдээллийн нэгжийн үйл ажиллагаа, тоног төхөөрөмжийн бэлэн байдал, ашиглалт, бүртгэл судалгаа			
		3.3.2. Программ хангамж, сүлжээний гэмтэл саатлыг засварласан бүртгэл, гэмтлийн тодорхойлолт, техник ашиглалтын паспорт хөтлөлт			
		3.3.3. Цахим, мэдээллийн аюулгүй байдлыг хангасан байдал			
		3.3.4. Болзошгүй гамшиг ослын үед холбоо зохион байгуулах дадлага сургууль хийсэн байдал, үр дүн			
3.4	Гамшгийн аюулын зарлан мэдээлэл	3.4.1. Гамшиг, аюулт үзэгдлээс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг, эрт зарлан мэдээллийн системийн төлөвлөлт ашиглалт, иргэд, олон нийтэд хүргэсэн бүртгэл			
		3.4.2. Зарлан мэдээлэл хүргэх бүдүүвч, бие бүрэлдэхүүний утас, гэрийн хаяг, цахим хаягийн тодотгол, зарлан мэдээлэл хүргэсэн байдал			
		3.4.3. Шуурхай удирдлагын операторын хөтөлбөл зохих баримт бичиг /Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2022 оны А/188 дугаар тушаал/			
3.5	Барилга байгууламж, техник, багаж хэрэгслийн бэлэн байдал, хадгалалт, хамгаалалт	3.5.1. Автомашин, механизмын бэлэн байдал, хувийн хэрэг хөтлөлт, хадгалалт, хамгаалалт ӨҮ, ТҮ-1, ТҮ-2, ТҮҮ хийсэн бүртгэл			
		3.5.2. Амьсгалын бие даасан төхөөрөмжийн өрөөний хаягжилт, агааржуулалт, цэвэрлэгээ үйлчилгээ, ариутгалын бодис, материал, техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн бүртгэл, техникийн үнэмлэх, хүлээлцсэн баримт, засвар үйлчилгээ хийсэн бүртгэл			



		3.5.3. Барилга байгууламжийн бүртгэл, паспортжуулалт, ашиглалтыг орон зайн мэдээллийн системд бүртгэж, зургалсан байдал			
3.6	Гамшиг, аюулт үзэгдэл, ослын хор уршгийг арилгах	3.6.1. Гамшиг, аюулт үзэгдэл, ослын дуудлагын бүртгэл, үүрэг гүйцэтгэх алба хаагч, багаж, техник хэрэгслийн томилгоожуулалт, шуурхай бүлэгтэй холбоонд орсон бүртгэл, удирдлагыг мэдээллээр шуурхай хангах үйл ажиллагаа,			
		3.6.2. Гамшигтай тэмцэх болон дадлага сургалтын арга хэмжээнд орон зайн мэдээллийн системийг ашигласан байдал			
		3.6.3. Гамшигийн хор уршгийн улмаас учирсан хохирол, хор уршгийг арилгахад зарцуулсан хөрөнгө, бүртгэл судалгаа /жил, улирал, сараар харьцуулсан байдлаар өсөлт, бууралт, хувь/			
3.7	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, химийн хорт болон аюултай бодисын чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	3.7.1. Албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан байдал, гарсан дүгнэлт, авсан арга хэмжээ, нарийн мэргэжлийн эмчийн хяналтад оруулсан байдал			
		3.7.2. Эмчлэх, сувилах эрхийн лицензийн хүчинтэй хугацаа, сунгасан байдал			
		3.7.3. Яаралтай тусламжийн болон нэн шаардлагатай үед хэрэглэх эмийн нөөц, жагсаалт			
		3.7.4. Эмч, сувилагч нарын ажлын байранд хөтлөгдөх баримт бичгийн бүртгэл, хөтлөлт			
		3.7.5. Эмчилгээний аппарат тоног, төхөөрөмжийн техник ашиглалтын паспортын тэмдэглэл, мэргэжлийн байгууллагаар засвар үйлчилгээ, тохируулга хийлгэсэн байдал			
		3.7.6. Эмнэлэгийн аюултай хог хаягдал устгах гэрээний хэрэгжилт, хугацаа			
		3.7.7. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын голомтод ажилласан бүртгэл судалгаа, шинжилгээ			
		3.7.8. Эрүүл мэндийн цахим бүртгэлийн системийн ашиглалт			
		3.7.9. Химийн болон цацрагийн ослын үед аврах, хор уршгийг арилгах, сэргээн босгох үйл ажиллагааг шуурхай удирдлага, зохицуулалтаар хангах, холбогдох хууль, дүрэм, журам судалсан байдал			

		3.7.10. Химийн хорт болон аюултай бодис ашиглах, хадгалах, тээвэрлэх, устгах үйл ажиллагаа эрхэлдэг тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж байгууллагын бүртгэл судалгаа, аюулгүй байдлыг хангах чиглэлээр мэргэжлийн байгууллагуудтай хамтарсан хяналт шалгалт зохион явуулж зөвлөмж, дүгнэлт өгч ажилласан байдал			
		3.7.11. Химийн хорт болон аюултай бодис, цацраг идэвхт бодисын тухай онолын болон ослын үед хэрхэн ажиллах талаар дадлага, сургалт, сурталчилгааг зохион байгуулах байдал			
		3.7.12. Цацраг, химийн бодисын нөлөөлөлөөс хамгаалах хүн нэг бүрийн хамгаалах хувцас, багаж хэрэгсэлийн чанар байдал, ашиглалт, хадгалалтад хяналт тавьдаг эсэх			
		3.7.13. Химийн хорт болон аюултай бодис ашиглах, хадгалах, тээвэрлэх, устгах үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагууд гарч болзошгүй ослын үед ажиллах төлөвлөгөөг боловсруулахад заавар зөвлөмж хяналт тавьж ажилласан байдал			
3.8	Анги, салбар, нэгжийн үйл ажиллагаа	3.8.1. Зарлан мэдээллийн дохио дамжуулах бүдүүвч, утасны дугаар, хаягийн тодотгол, ажилласан, удирдамж, илтгэх хуудас			
		3.8.2. Гамшиг аюулт үзэгдэл, осол, томилгоот ээлжийн томилгоо, үүрэг гүйцэтгэл, бүртгэл			
		3.8.3. Алба хаагчдын ажил дүгнэсэн байдал			
		3.8.4. Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт, тайлан, танилцуулга			
		3.8.5. Мэргэжлийн болон холбогдох дүрэм журам, эрх зүйн баримт бичгийг судлуулах, сургалт явуулсан тэмдэглэл, шүүлэг авч үр дүнг тооцсон байдал			
		3.8.6. Алба хаагчдын бие бялдар, албаны бэлтгэл бэлэн байдлын норматив хангах байдал			
		3.8.7. Анги, салбарын үйлчлэх хүрээний нутаг дэвсгэрийн бүдүүвч зураг, зам гарц, усан хангамжийн судалгаа, тодотгол, баталгаажуулалт, гамшиг, аюулт үзэгдэл, ослын үед хөтлөх даргын ажлын зураг			

		3.8.8. Гал түймэр унтраах, аврах ажиллагааны нотломж бичих зааврын бүрдэл /дуудлагын хуудас, схем зураг, ярилцлага, танилцуулга, баримтжуулсан гэрэл зураг дуудлагаар ажилласан бүртгэл/ удаан хугацаагаар болон 2-оос дээш тасаг, бүлэг ажилласан, хүний амь нас өртсөн, их хэмжээний хохиролтой голомтод ажилласан.			
		3.8.9. Дасгал сургууль /тактик, тархалтын, өдөр тутмын/, шуурхай төлөвлөгөө, карт			
		3.8.10. Алба хаагчийн дэлгэрэнгүй бүртгэл, алба хаагч нэг бүртэй ажилласан тэмдэглэл.			
		3.8.11. Алба хаагчийн өдөр тутмын ажлын тэмдэглэл			
		3.8.12. Алба хаагчийн хөдөлмөр хамгаалал, тусгай зориулалтын хувцасны ашиглалтын байдал			
3.9	Нисэх нэгжийн үйл ажиллагаа	3.9.1. Нисгэгч, инженер техникийн бүрэлдэхүүн болон нислэгт үйлчилсэн алба хаагчдыг ангийн захирагчийн тушаалаар томилсон байдал			
		3.9.2. Нисгэгч, инженер техникийн бүрэлдэхүүний мэргэжлийн үнэмлэх болон бусад бичиг баримтын бүрдэл			
		3.9.3. Нислэгийн аюулгүй ажиллагааны зохицуулалт, чанар баталгаажуулалтын баримт бичгийн бүрдэл			
		3.9.4. Нисдэг тэрэгний бэлэн байдал, бичиг хэргийн хөтлөлт, хадгалалт, хамгаалалт			
		3.9.5. Нислэгийн төлөвлөлт, захиалга, зохицуулалтын бичиг баримтын бүрдэл			
		3.9.6. Нисэх бүрэлдэхүүний сургалт, дадлага, хяналт, үр дүнг тооцсон байдал			
		3.9.7. Дадлагажуурын ашиглалтын журмын дагуу ашигласан байдал, дадлагажуурын баримт бичиг, техникийн засвар үйлчилгээний төлөвлөлт, гүйцэтгэл			
3.10	Нисэх нэгжийн инженер, техникийн албаны үйл ажиллагаа	3.10.1. Техник үйлчилгээний төлөвлөлт, төлөвлөлтийн дагуу хийж гүйцэтгэсэн техник үйлчилгээний ажил			
		3.10.2. Техник үйлчилгээ явуулахад шаардлагатай багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангасан байдал			
		3.10.3. Техник үйлчилгээний бичиг баримт боловсруулалт, хадгалалт			

3.11	Нислэгийн үйл ажиллагаа	3.11.1. Нислэгийн төлөвлөгөө, нислэгийн урьдчилсан бэлтгэл, нислэгийн захиалга, нислэгийн үүргийн хуудас, захиалгат нислэгийн төлбөр тооцоо			
		3.11.2. Нисдэг тэрэгний шатахууны ашиглалт, хадгалалт, хамгаалалт, бүртгэл			
<b>61</b>			<b>0-100</b>		

### Дөрөв. Санхүүгийн үйл ажиллагаа

№	Шалгуур үзүүлэлт		Авсан оноо	Хувь чанар	Дундаж оноо хувь
4.1	Төсвийн төлөвлөлт гүйцэтгэл, ил, тод байдал	4.1.1. Төсвийн төслийн бодит үндэслэл, хамт олны санал, зөвлөмжийг тусгасан байдал			
		4.1.2. Өглөг, авлага, шалтгаан нөхцөл, баталгаажуулалт, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ			
		4.1.3. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, бодит байдал			
		4.1.4. Алба хаагчдад зориулсан санхүүгийн мэдээллийн самбар гаргасан байдал, санхүүгийн мэдээллийн шинэчлэлт,			
4.2	Нягтлан бодох бүртгэл	4.2.1. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлж буй байдал			
		4.2.2. Хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлангийн чанар, үнэн зөв байдал, иж бүрдэл			
		4.2.3. Санхүүгийн мэргэжлийн болон хяналт шалгалтын байгууллагуудын шалгалтын үр дүн, дүгнэлт санхүүгийн зөрчил, зөвлөмж, акт, албан шаардлагын хэмжээ, авсан шалтгаан, өгсөн үүргийн биелэлт			
		4.2.4. Үндсэн болон эргэлтийн хөрөнгийн хагас, бүтэн жилийн тооллогын бүртгэл, санхүүгийн тайланд тусгасан байдал			
		4.2.5. Нэмэлт санхүүжилт, дансны санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан байдал			
		4.2.6. Алба хаагчдын цалин хөлсний тогтоолт, цагийн бүртгэлийн тулгалт, бодолт, олголт, татвар, нийгмийн даатгалын суутгал			
		4.2.7. Алба хаагчдад шагнал, урамшуулал олгож, шийтгэл ногдуулсан байдал,			

		ажиллагсадтай хөдөлмөрийн гэрээ байгуулсан байдал			
		4.2.8. Үйлдвэрлэл, үйлчилгээний үйл ажиллагаанаас олсон ашиг орлого, зарцуулалт, бүртгэл			
4.3	Хөрөнгийн бүртгэл, эд хариуцагчийн үйл ажиллагаа	4.3.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа материал, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилт			
		4.3.2. Өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагаа, үндсэн хөрөнгийн бүртгэл, татвар, даатгалын төлөлт, гэрчилгээ, хувийн хэрэг хөтлөлтийн байдал			
		4.3.3. Няравын бараа материалын тайлан, агуулахын бүртгэл хөтлөлт, бодит байдал			
		4.3.4. Шатахуун болон үнэт цаасны тооцоо, тайлан, удирдлагаас тавих хяналт, баталгаажилт			
		4.3.5. Няравын агуулахын эмх цэгц, бараа материалын хадгалалт, хамгаалалт			
		4.3.6. Алба хаагчдын хувцас хэрэглэл, эд хөрөнгийн хангалт, ашиглалттай холбоотой төлбөр тооцоо, картын бүртгэл хөтлөлт			
		4.3.7. Өөрийн дотоод нөөц бололцоо, хандив тусламжаар бий болсон хөрөнгө, байгууллагад хийгдсэн ажил, арга хэмжээ			
		4.3.8. Дээд шатны байгууллага болон орон нутгийн удирдлага, иргэд, хуулийн этгээдийн дэмжлэг, хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажил, арга хэмжээ			
<b>20</b>			<b>0-100</b>		

**Тав. Улсын нөөц, хүмүүнлэгийн тусламжийн анги, салбар, цэгийн үйл ажиллагаа**

№	Шалгуур үзүүлэлт		Авсан оноо	Хувь чанар	Дундаж оноо хувь
5.1	Хууль тогтоомжийн хэрэгжилт	5.1.1. Улсын нөөцийн тухай, Төрийн болон албаны нууцын тухай хууль болон бусад холбогдох хууль шийдвэрийн хэрэгжилт			
		5.1.2. Авлагын барагдуулалт, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүн			
		5.1.3. Хүмүүнлэгийн тусламжийн бараа материалын бүрдүүлэлт, хадгалалт, зарцуулалт, бүртгэл			
5.2	Улсын нөөцийн	5.2.1. Нөөцийн бараа, материалын хадгалалт, чанар стандарт			

	бараа, материалын хадгалалт, хамгаалалт	5.2.2. Нөөцийн бараа, материалын бүрдүүлэлт, зарцуулалттай холбоотой баримт бичгийн бүрдэл, хугацаат тайлан мэдээ			
		5.2.3. Нөөцийн бараа, материалыг батлагдсан хуваарь, төлөвлөгөөний дагуу сэлгэлт, баталгаажуулалт, тайлан, мэдээ			
5.3	Агуулахын бэлэн байдал	5.3.1. Агуулахын болон тоног төхөөрөмжийн хувийн хэрэг хөтлөлт, баяжуулалт			
		5.3.2. Агуулахын ариутгал халдваргүйтгэл, цэвэрлэгээ, эмх цэгц, бараа, материалын хаягжуулалт			
		5.3.3. Харуул хамгаалалт, гал түймэр унтраах анхан шатны багаж, хэрэгслийн бүрдүүлэлт, бэлэн байдал			
<b>9</b>			<b>0-100</b>		

### Зургаа. Эрүүл мэнд, үйлдвэрлэл, хангалт үйлчилгээний үйл ажиллагаа

№	Шалгуур үзүүлэлт		Авсан оноо	Хувь чанар	Дундаж оноо хувь
6.1	Тусламж, үйлчилгээний тасралтгүй байдал	6.1.1. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг холбогдох стандартад нийцүүлэн, чанартай, хүртээмжтэй хийсэн байдал			
		6.1.2. Эмчилгээний үр дүнг тооцож, харьцуулалт хийсэн байдал			
		6.1.3. Үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн судалгааг тодорхойлж, үр дүнг тодорхойлсон байдал			
6.2	Хоол үйлдвэрлэлийн үйл ажиллагааг холбогдох стандартын дагуу зохион байгуулалт	6.2.1. Хоол үйлдвэрлэлийг зохих стандарт, шаардлагад нийцүүлдэг байдал			
		6.2.2. Ундны ус, хөрсний нян судлалын болон арчдасын шинжилгээ хийсэн байдал			
		6.2.3. Хоол үйлдвэрлэлийн технологийн явцад тогтмол хяналт тавьж ажилласан бүртгэл, танилцуулсан байдал			
6.3	Бүтээгдэхүүний стандарт норм, чанар байдал	6.3.1. Үндсэн болон туслах бараа, материалын үнийн саналын судалгаа, материалын өртөг тооцсон байдал			
		6.3.2. Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн орц норм тодорхойлсон байдал			
		6.3.3. Дамжлага дундын болон эцсийн бүтээгдэхүүний чанар шалгасан, чанарын карт хөтөлсөн байдал			
6.4		6.4.1. Хувцасны загварыг гаргаж, сайжруулсан, эх үлгэр бэлтгэсэн, эх			

		загварыг оёулж туршсан, шалгасан, техникийн баримт бичиг боловсруулсан байдал			
	Хувцас үйлдвэрлэлийн явц, хяналт	6.4.2. Материалын хэмнэлт гаргаж үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэхээр гаргасан санаачлага, хийгдсэн ажил, julive программын ашиглалт			
		6.4.3. Үйлдвэрлэлийн төлөвлөлт, төлөвлөгөөт нормын биелэлт, цахим системийн ашиглалтын байдал			
		6.4.4. Ажлын зураг авалт хийж, нормт цагийг тогтоож, дамжлагын ажилбар тус бүрийг үнэлсэн, дамжлагын ачааллыг тооцон ажилчдад хуваарилалт			
		6.4.5. Үйлдвэрийн ажилчдын цалингийн тооцооны бүртгэл хөтлөлт, дамжлагын үнэлгээний дагуу ажилчдын бүтээмжийн үнэлгээ			
		6.4.6. Шинэ загварыг үйлдвэрлэлд оруулж, үйлдвэрлэх дамжлагын хуваарийг гаргаж, ажилчдыг дадлагажуулж, зааварчилгаа өгсөн байдал			
		6.4.7. Бүтээгдэхүүний техникийн баримт бичгийг боловсруулж, хөдөлмөрийн аюулгүй байдлын зааварчилгаа өгсөн байдал			
6.5		Хангалт зохион байгуулалт	6.5.1. Хангалтын төлөвлөлт, тооцоо судалгаа, хуваарилалтын оновчтой байдал		
	6.5.2. Хангалтын хувцас хэрэглэлийн чанар, стандартыг хангасан байдал				
	6.5.3. Хангалтын техник, тоног төхөөрөмжийн чанар, стандартыг хангасан байдал				
	6.5.4. Хангалтын хүнсний бараа бүтээгдэхүүний чанар, стандартыг хангасан байдал				
	6.5.5. Хангалтын нөөц бүрдүүлэлтийн зохион байгуулалт, хэрэгжилт				
	6.5.6. Хангалт олголтын зохион байгуулалт, хүртээмжтэй байдал				
	6.5.7. Агуулахын технологи, стандартыг хангасан байдал				
	6.5.8. Хөдөө аж ахуйн чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүн				
6.6	Техникийн бэлтгэл, бэлэн байдал	6.6.1. Техникийн комиссын үйл ажиллагаа			
		6.6.2. Жолооч бүрэлдэхүүний мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ			

		6.6.3. Автомашин, техник хэрэгсэл хүлээлгэн өгсөн, хүлээн авсан тухай нотломж, бүрдүүлэлт			
		6.6.4. Техникийн тоо бүртгэл хөтлөлт, судалгаа			
		6.6.5. Техникийн өдөр тутмын үзлэг шалгалт, бүртгэл хөтлөлт			
		6.6.6. Техникийн засвар үйлчилгээний багаж, тоног төхөөрөмжийн ашиглалт, бүрэн бүтэн байдал			
6.7	Алба хаагчдын сэтгэл зүй, бие бялдрын бэлтгэлжилт	6.7.1. Цэргийн алба хаагчдын бие бялдар бэлтгэлжилтийн ерөнхий хөгжлийг дээшлүүлэхэд чиглэсэн арга хэмжээг зохион байгуулж үр дүнг тооцсон байдал			
		6.7.2. Онцгой байдлын албаны алба хаагчдын дунд тэмцээн уралдааныг зохион байгуулж, олон нийтэд суртчилан таниулсан байдал, бүртгэл судалгаа			
		6.7.3. Алба хаагчдын бие бялдар, сэтгэл зүйн судалгаа хийж, үр дүнг тодорхойлсон байдал			
		6.7.4. Онцгой байдлын байгууллагын хэмжээнд зохион байгуулсан нэгдсэн арга хэмжээнд алба хаагчдыг хамруулсан бүртгэл, судалгаа			
6.8	Их спортын болон үндэсний спортын төрлүүдийг хөгжүүлэх олон улс, тив, дэлхий тэмцээнд амжилт	6.8.1. Дасгалжуулагчид бэлтгэл, сургалт, тэмцээний календарчилсан төлөвлөгөө, сургалтын хуваарь, бүртгэл, харьцуулсан судалгаа, тамирчдын амжилтын судалгаа авсан арга хэмжээ			
		6.8.2. Тамирчид жилийн бэлтгэлийн төлөвлөгөө, өрсөлдөгч тамирчдын судалгаа, өдрийн тэмдэглэл, дотоод, гадаадын тэмцээнд үзүүлсэн амжилт, үр дүн			
		6.8.3. Спортын анагаах ухааны чиглэлээр мэргэшиж баг тамирчдад эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлсэн судалгаа			
		6.8.4. Онцгой байдлын байгууллагын хэмжээнд бүртгэлтэй байгаа тамирчдын судалгаа			
6.9	Спорт заалны ашиглалт, зохион байгуулалт	6.9.1. Онцгой байдлын алба хаагчид хуваарийн дагуу спорт зааланд үйлчлүүлсэн байдал, бүртгэл			
		6.9.2. Гадны байгууллагуудтай спорт заал ашиглуулахаар хийсэн гэрээ, үнэлгээ, хуваарь, гэрээний гүйцэтгэл, төлбөр тооцоо			



		6.9.3. Спорт заалаар үйлчлүүлэгчдийн бүртгэл, эд хөрөнгө, спортын хэрэглэл материалыг хүлээлцсэн байдал,			
<b>41</b>			<b>0-100</b>		

**Долоо. Гамшгаас хамгаалах судалгаа, эрдэм шинжилгээний үйл ажиллагаа**

№	Шалгуур үзүүлэлт		Авсан оноо	Хувь, чанар	Дундаж оноо,
7.1	Алба хаагчдын чадавхын ахиц	7.1.1. Эрдмийн зэрэг /магистр, доктор/, цолтой алба хаагчдын судалгаа, эзлэх хувийг нэмэгдүүлэх талаар авсан арга хэмжээ гарсан үр дүн			
		7.1.2. Онцгой байдлын байгууллагын хүний нөөцийн чадавхыг дээшлүүлэх, хөгжүүлэх чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажил, арга хэмжээ, үр дүн			
7.2	Судалгаа, эрдэм шинжилгээний ажлын үр дүн	7.2.1. Эрдэм шинжилгээ судалгааны ажлыг гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд нэвтрүүлж, үр дүнг тооцож буй байдал			
		7.2.2. Лабораторийн ашиглалт, үр дүн			
		7.2.3. Гүйцэтгэсэн эрдэм шинжилгээ, туршилт зохион бүтээх ажлын тайлан, бий болгосон шинэ үр дүн, түүнийг нэвтрүүлж ашиглаж байгаа байдал			
7.3	Эрдэм шинжилгээний бүтээл туурвих, нийтийн хүртээл болгох ажлын хэрэгжилт	7.3.1. Эрдэм шинжилгээний илтгэл, өгүүлэл хэлэлцүүлсэн, хэвлүүлсэн байдал үр дүн			
		7.3.2. Ном, сурах бичиг, гарын авлага, сэтгүүлийн чанарт гарсан үр дүн, нийтийн хүртээл болсон байдал			
		7.3.3. Эрдэм шинжилгээний болон онол, практикийн хурал, хэлэлцүүлгийн зохион байгуулалт, хамрагдалт, үр дүн			
		7.3.4. Судалгааны ажлын тайланг судалгааны нэгдсэн сангийн системд байршуулах, хянах, засварлах, хэрэглэгчийн саналыг хүлээн авах ажлыг зохион байгуулсан байдал			

7.5	Хамтын ажиллагаа	7.5.1. Онцгой байдлын байгууллагын болон бусад эрдэм шинжилгээний байгууллагатай хамтын ажиллагааг өргөжүүлж, инновацийн чиглэлээр хамтран хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүн			
		7.5.2. Бусад байгууллагатай хамтарсан судалгаа, төсөл, хөтөлбөр гүйцэтгэсэн байдал, үр дүн, төлбөр тооцоо			
<b>11</b>			<b>0-100</b>		

--oOo--

**Төсөл**

Онцгой байдлын ерөнхий газрын даргын  
2024 оны ... дугаар сарын ...-ний өдрийн  
А/...дугаар тушаалын дөрөвдүгээр  
хавсралт

Албан тушаалтныг шалгах шалгуур үзүүлэлт

Нэгж	Цол, овог нэр	Албан тушаал	Ажилласан жил	Шалгасан албан тушаалтан
.....	.....	.....	.....	

Д/д	Арга хэмжээ	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт, хэрэгжилт, шалтгаан нөхцөл	Оноо		Хувь		
			Авбал зохих	Авсан			
1.	Гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулж, сар, улирлаар үнэлгээ дүгнэлт авсан байдал						
2.	Албан тушаалтны тодорхойлолтын зорилт, арга хэмжээ	1 дүгээр зорилтын хүрээнд	1.1.				
			1.2.				
			1.3.				
		2 дугаар зорилтын хүрээнд	2.1				
			2.2.				
			2.3.				
		3 дугаар зорилтын хүрээнд г.м	3.1.				
			3.2.				
			г.м.				
3.	Баримт бичгийн төлөвлөлт, боловсруулалт, тайлан мэдээний чанар, үр дүн						
4.	Ур чадвар (манлайлал, гадаад хэлний мэдлэг, бүтээлч санаа...г.м)						
5.	Онолын мэдлэг (тестийн шалгалтад авсан оноогоор)						
6.	Сайшаал, шийтгэлийн байдал						

7.	Бие бялдрын бэлтгэлжилт, норматив				
8.	Цэргийн хэргийн мэдлэг, цэрэгжилт жагсаалч байдал				

**ШАЛГАЛТЫН ДҮН, БАТАЛГААЖУУЛАЛТ**

Нийт арга хэмжээний тоо	Оноо		Дүн		Баталгаажуулалт	
	Авбал зохих	Авсан	Хувь	Үнэлгээ	Шалгуулсан	Шалгасан
.....	.....	.....	.....	.....	.....	.....

**БАТАЛГААЖУУЛАЛТ:**

**АЖЛЫН ХЭСЭГ:**

Ахлагч

.....  
(албан тушаал)

/...../  
(гарын үсэг)

20.... оны.... дугаар сарын .....-ны өдөр  
(огноо)

Гишүүн

.....  
(албан тушаал)

/...../  
(гарын үсэг)

20..... оны.... дугаар сарын .....-ны өдөр  
(огноо)

**ШАЛГУУЛСАН:**

Нэгжийн дарга

.....  
(албан тушаал)

/...../  
(гарын үсэг)

Тэмдэг

20..... оны.... дугаар сарын .....-ны өдөр  
(огноо)

Алба хаагч

.....  
(албан тушаал)

/...../  
(гарын үсэг)

20..... оны.... дугаар сарын .....-ны өдөр  
(огноо)

--oOo--